




Монголын Үйлдвэрлэлийн Хөгжлийн Төлөө



Хямралын үеийн удирдлага

Бизнес эрхлэгчид хямралын үед хамгийн хүнд хэцүү сорилтой тулгардаг. Энэ нь манантай үед хөлгөө удирдах ахмад лугаа адил юм.

Хямрал нүүрлэсэн үед бидний мэдэх стратеги төлөвлөлт, дэвшүүлсэн зорилгууд, ажил үүргийн процессууд гэх мэт бүх л дүрэм журмууд хүчингүй болдог. Товчоор хэлэхэд ямар ч зүг чиглэлгүй болж бидэнд айдас бий болж эхэлдэг. Тэгвэл хямралын үед хэрхэн компаниа удирдах вэ?

1. Бодитоор харан хүлээн зөвшөөрөх:

- Юуны өмнө удирдагч хямралыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хямрал өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж байдаг.
- Хямрал бол боломж юм. Яагаад гэвэл хямрал биднийг зайлшгүй хөгжин дэвшиж, урагшлахыг шаарддаг. Бизнес эрхлэгчид байнга шинийг эрэлхийлэн, хөгжиж чадсанаар зах зээл дээр тэсэж үлдэж чаддаг.

2. Оновчтой дүн шинжилгээ хийх:

- Сэтгэл хөдлөлд автан яарч шийдвэр гаргахгүй байх.
- Тулгарч болохуйц эрсдэлүүдийг тодорхойлох, тохирсон арга хэмжээг авах.
- Асуудалд анхаарал хандуулахын оронд шийдэл болон боломжид төвлөрөх.

3. Асуудлыг шийдвэрлэх:

- Боломжит хувилбарыг сонгон, тохирсон шийдлийг хэрэгжүүлэх.
- Нарийн төвөгтэй асуудлуудыг шийдэхэд та “Хэрэглээний шинжилгээ”-ний загварыг ашиглаж болно.

Хямрал бүрийн дараа дахин сэргэдэг бичигдээгүй хууль бий. Бидний гол асуудал хямрал биш харин түүнд хандаж байгаа бидний хандлага юм!

ВРN-ийн зүгээс энэ хүнд цаг үед бизнес эрхлэгчдэдээ зориулан шинэлэг, практикт суурилсан онлайн сургалтуудаа тогтмол санал болгож байна.



ВРN Монгол салбарын Швейцар захирал
Маркус Эппер

Талархал



Бид 2015 оноос хойш ВРN ОУБ-тай хамтын ажиллагааны хүрээнд бизнесийн удирдлагын чиглэлээр олон чухал сургалт, зөвлөх үйлчилгээнд хамрагдаж ирсэн. Шударга зарчимтай, ёс зүйтэй бизнес эрхэлснээр ирээдүйдээ хамгийн том үнэ цэнийг бий болгохын сацуу бизнес хийх нь “мөнгө олох” гэдгээс илүү том хүсэл зорилгыг агуулж байдаг гэдгийг ойлгон үүнийгээ үйл ажиллагаандаа мөрдүүлэхээр хичээж суралцаж яваа билээ.

Мөн Covid-19 цар тахлаас шалтгаалсан эдийн засгийн хямралын үед ВРN байгууллагын зүгээс бидэнд тодорхой хэмжээний санхүүгийн туслалцаа үзүүлсэн нь ёстой цагаа олсон маш чухал дэмжлэг болсонд талархаж байна. Учир нь ЖДҮ-ийн хувьд ажлын байраа хадгалж үлдэх, түрээсийн зардал, эргэлтийн болон шаардлагатай тоног төхөөрөмжийн санхүүжилт зэрэгт санхүүгийн хэрэгцээ маш их байсан.

Тус байгууллагаас 2020 оны 9 сард зохион байгуулсан “Зах зээлд чиглэсэн компанийн удирдлага” сэдэвт сургалтын дараа ОУ-ын мэргэшсэн зөвлөх Тобиас Амманнаас ганцаарчилсан бизнесийн зөвлөгөө авах боломжийг олгосон нь өөрийн бүтээгдэхүүний давуу болон сул тал, брэндийн алсын харааг тодорхойлоход юуг анхаарах шаардлагатай зэрэг маш чухал зөвлөмжүүдийг авлаа.

Та бүхэндээ ажлын өндөр амжилт хүсье.

Бид та бүгдийнхээ итгэлийг хүлээн, хичээнгүйлэн ажилласаар байх болно.

Хүндэтгэсэн:

Алиман сар үйлдвэрийн хамт олон

“Emergency Fund” буюу “Яаралтай үеийн санхүүгийн хөнгөлөлттэй дэмжлэг”

BPN-Office:

ULAANBAATAR

“Дэлхий нийтийг хамарсан COVID-19 цар тахлын улмаас өнөөдөр улс орон бүр урьд өмнө нь тохиолдож байгаагүй эдийн засгийн хүндрэл, хямралтай нүүр тулж байгаа билээ.

Бизнесийн цар хүрээнээс үл хамааран бүх төрлийн бизнес, ялангуяа жижиг, дунд үйлдвэрүүд (ЖДҮ) үйл ажиллагаагаа хэвийн явуулахад бэрхшээлтэй тулгарч байна.

“BPN” Олон улсын байгууллагаас үүсээд байгаа онцгой нөхцөл байдлыг даван туулах, хариу арга хэмжээ авах хямралын үеийн бодлогыг авч хэрэгжүүлж эхэллээ. Энэ бодлогын хүрээнд “Яаралтай үеийн санхүүгийн хөнгөлөлттэй дэмжлэг”-ийг шаардлагатай бизнес эрхлэгчдэдээ олгон ажиллаж байна.

Энэ нь бизнес эрхлэгчдийн тогтвортой үйлдвэрлэлийн амин чухал хэрэгцээ болох цалин хөлс, түрээс, болон түүхий эд материал зэрэгт зориулсан санхүүгийн дэмжлэг болох хоёр жилийн хугацаатай, хүүгүй зээл юм.

BPN байгууллагын хөтөлбөрийн хүрээнд олгож буй хөнгөлөлттэй дэмжлэг нь цар тахлын үеийн бэрхшээлийг даван туулахад хөтөлбөрийн оролцогчдод бодит дэмжлэг болж чадаж байгаа нь бизнес эрхлэгчдийн талархсан сэтгэгдлээс харагдаж байгаа билээ.

Бид цаашид ч цаг үетэйгээ нийцсэн олон үйл ажиллагааг хөтөлбөрийн оролцогчдодоо санал болгон ажиллах болно.

"Coaching" үйлчилгээ

Coaching гэдэг нь үйлчлүүлэгчээ хувь хүн болон мэргэжлийнх нь хувьд нөөц бололцоо, чадварыг нь нээн илрүүлж түүнийгээ бүрэн дүүрэн ашиглах замаар ахисан түвшинд хүргэж, амжилтад хөтлөхийг хэлнэ.

Өнөөдөр амжилттай байгаа хувь хүн болон байгууллагууд бүгд Coach-тэй хамтран ажиллаж байна.

Саяхныг хүртэл компаниуд бизнесийн зөвлөх үйлчилгээг түлхүү авч байсан бол өнөөдөр Coaching үйлчилгээг илүүд үзэж байна.

Учир нь бизнес зөвлөгөөний хүрээнд тухайн экспертийн боловсруулсан төлөвлөгөө болон шийдлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байсан бол Coaching нь бизнес эрхлэгчийг ирээдүйн зорилгод нь чиглүүлж, өөрөөр нь тулгарч буй асуудал болон сорилын шийдлийг олоход нь тусладаг.

Аливаа бизнесийн нөөц боломж, онцлогийг тухайн бизнес эрхлэгч өөрөө хэнээс ч илүү сайн мэдэх тул түүний боловсруулсан төлөвлөгөө, гаргасан шийдвэр бизнесийг нь амжилтад хүргэх гол түлхүүр болно.

BPN байгууллагын “Coaching Skills Program” – ийн хүрээнд Англи улсын Лондон хотод төвтэй “Creative Mieter” компанийн “Business Focused Executive Coaching” сургалтад баг хамт олноо хамруулж, ур чадварыг нь дээшлүүлсэн.

Бидний зүгээс цаашдаа хөтөлбөрийн оролцогчиддоо “Бизнес Coaching” үйлчилгээг түлхүү санал болгож, тэдэнд тулгарч буй асуудлын учир шалтгааныг таньж, шийдлээ олох арга замд нь чиглүүлж өгөхөд туслах болно.



Хөтөлбөрийн оролцогч
“Өөдлөн дэвжих” ХХК-ийн
захирал Г.Цацралтуяа

Хөтөлбөрийн оролцогч “Өөдлөн дэвжих” ХХК-ийн захирал Г.Цацралтуяа Манай компани нь 2013 оноос хагас боловсруулсан болон бэлэн мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэн үйл ажиллагаагаа явуулж байна. БПН-ий хөтөлбөрт хамрагдаад өөрийгөө юу хийж байгаагаа ойлгосон. Өмнө нэмүү өртөг гэж зөндөө сонсож байсан ч яг юу юм бэ гэдэг талаар ойлголтгүй явж байсан ба өөрийгөө дотоодын үйлдвэрлэгч нэмүү өртөг бүтээдэг их чухал хүн гэдгээ сайн ойлгож авсан. Мөн “Цагийн менежмент” сургалтаар сурсан бидний цаг зарцуулалтын хамгийн чухал зүйл болох Паретогийн зарчмыг амьдралдаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Өглөө ажилдаа ирээд эхний 2 цагийг 80/20-ийн зарчмаар зарцуулж хэвшил болгосон. Мөн саяхан зохион байгуулагдсан “Хямралын үеийн удирдлага” онлайн сургалтад хамрагдан хямралыг аюул гэж харахаасаа илүүтэйгээр боломж хэмээн харан, аливаа зүйлийг бүтээлчээр сэтгэж, эерэг хандлагатай байх хэрэгтэй гэдгийг ойлгосон. Ер нь БПН-ийхээ сургалтуудыг тэсэн ядан хүлээдэг. Тархи цэнэглэгч БПН-ий хамт олондоо маш их баярлалаа. Цаашдын ажил үйлсэд нь амжилт хүсье.

Онлайн сургалтуудын мэдээлэл болон хуваарь



Цагийн менежмент

2020.10.29-30 /2 өдөр/

Цаг төлөвлөлтийн 10 дүрэм

Хүний амьдралд байнга тохиолдож байдаг стресс, бухимдал, сандрал зэргийг 10 дүрмийн тусламжтайгаар даван туулж, амжилтад хүрнэ.

Яарч сандрах, стрессдэх болон зөв төлөвлөөгүйн улмаас бий болох сөрөг нөлөөнд автахгүй байх чадвар эзэмшинэ.



Байгууллагын ёс зүй

2020.11.12 /90 минут/

Ёс зүй гэж юу вэ?

Байгууллагын ёс зүй нь яагаад өрсөлдөх чадварын чухал хүчин зүйл вэ?

Ямар үнэт зүйл дээр компани оршин тогтнодог вэ?

Хүмүүсийг юу аз жаргалтай болгодог вэ?

Швейцарын бодит жишээ



Алсын хараа – Зорилго – Амжилт

2020.11.30 /90 минут/

Бидэнд алсын хараа яагаад хэрэгтэй вэ?

Алсын хараатай хүнийг хэрхэн таних вэ?

Томоохон зорилгууддаа хэрхэн хүрэх вэ?

Байгууллагын алсын харааг хэрхэн тодорхойлох вэ?

Швейцарын бодит жишээ

